



MNAS AC06

МОНГОЛ УЛСЫН
ИТГЭМЖЛЭЛИЙН
ТОГТОЛЦОО

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БАТАЛГААЖУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ИТГЭМЖЛЭЛИЙН ШАЛГУУР

Нэгдсэн үндэсний гудамж 5/1, 3Г-ын II байр
Улаанбаатар 15160, Монгол Улс
Утас: (976) 77073689

Цахим хуудас: www.mnas.gov.mn
Цахим шуудан: info@mnas.gov.mn

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ

ХЭВЛЭСЭН ОГНОО:
05.01.2023

ӨӨРЧЛӨЛТ NO: 01
ӨӨРЧЛӨЛТИЙН ОГНОО: 02.12.2024

0 Оршил

Аж үйлдвэрийн салбар, менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын хэрэгцээ шаардлагыг хангах зорилгоор Монгол Улсын засгийн газар болон Үндэсний итгэмжлэлийн төв хамтарч Чанарын менежментийн тогтолцоо (ЧМТ), Байгаль орчны менежментийн тогтолцоо (БОМТ) болон бусад менежментийн тогтолцооны баталгаажуулалтын итгэмжлэлийн тогтолцоог бий болгохоор ажиллаж байгаа билээ.

MNAS-ийн баталсан Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны эхний шалгуурыг Монгол Улсад явагдаж буй баталгаажуулалтын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, гадаад улс болон бүс нутаг, олон улсын гэрээнд нэгдэх зорилгоор ISO/IEC 17021 болон ISO/IEC 27006 стандартын дагуу боловсруулсан. Итгэмжлэлийн шалгуурыг IAF/APAC-аас шинээр хэвлэгдсэн стандарт, заавал дагаж мөрдөх баримт бичгийн лавлагааг тусгах зорилгоор тогтмол шинэчилдэг.

1 Хамрах хүрээ

Энэхүү баримт бичиг нь Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо (МАБМТ)-ны баталгаажуулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч хөндлөнгийн байгууллагыг MNAS-аас Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны баталгаажуулалтын үйл ажиллагааг явуулах чадвартай, найдвартай гэж үнэлэхэд тавигдах шаардлагыг тодорхойлно.

2 Шалгуур

- Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны баталгаажуулалт хийх итгэмжлэл хүссэн Баталгаажуулалтын байгууллага нь ISO/IEC 17021 “Тохирлын үнэлгээ. Менежментийн тогтолцооны аудит болон баталгаажуулалт хийх байгууллагад тавих шаардлага” болон ISO/IEC 27006-1 “Мэдээллийн аюулгүй байдал, кибер аюулгүй байдал, нууцлал хамгаалалт — Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоонд аудит, баталгаажуулалт хийх байгууллагад тавих шаардлага — 1-р хэсэг: Ерөнхий” стандартад заасан шаардлагуудыг хангах үүрэгтэй.
- ISO/IEC 17021 болон ISO/IEC 27006-1 стандартын хувь, хуулбарыг Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)-аас авч болно.

Тайлбар: ISO/IEC 17021 болон ISO/IEC 27006-1 стандартын шинэчлэлийн хүрээнд IAF болон APAC-аас тогтоосон баримт бичигт өөрчлөлт орох бүрт MNAS нь итгэмжлэлийн шалгуурын нэг хэсэг болгон ашиглана.

3 ISO/IEC 27006-1 стандартын шаардлагын удирдамж

MNAS нь ISO/IEC 27006-1 стандартын шаардлага болон IAF-н заавал мөрдөх баримт бичгүүдийг нэмэлт шалгуурын баримт бичгээр ашиглана.

Итгэмжлэлийн шалгуурын талаар тодруулга хэрэгтэй бол MNAS нэмэлт тайлбар өгнө.

Тайлбар: IAF-н заавал мөрдөх баримт бичгийг IAF цахим хуудаснаас англи, MNAS цахим хуудаснаас монгол хэлээр тус тус үнэгүй татаж авах боломжтой.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AC06	Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн шалгуур	
Хэвлэсэн огноо: 05.01.2023	Өөрчлөлт No:01	Хуудас: 1/3
	Өөрчлөлтийн огноо: 02.12.2024	

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ

4 Итгэмжлэлийн хүрээ

MNAS нь энэ схемийн итгэмжлэлд холбогдох салбаруудыг итгэмжлэлийн хүрээгээр тодорхойлохгүй байхаар шийдсэн бөгөөд итгэмжлэлийг ISO/IEC 27006-1 стандартын дагуу олгоно.

5 Баталгаажуулалтын байгууллага (ББ)-ын чадамж

MNAS-н итгэмжлэл нь тухайн баталгаажуулалтын байгууллага нь ISO/IEC 27001 Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны баталгаажуулалтыг хийх чадавхтайг харуулна. Баталгаажуулалтын байгууллага нь Гуравдагч талын шударга, чадавхтай үнэлгээгээр Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо нь тогтоосон шаардлагыг хангаж буй итгэл найдварыг бүх талуудад өгөх үүрэгтэй.

Баталгаажуулалтын байгууллагын чадавхийг ISO/IEC 17021 болон ISO/IEC 27006-1 стандартын холбогдох шалгуурт нийцэж буй эсэхийг үнэлэх замаар тодорхойлно.

Баталгаажуулалтын байгууллага нь аудитор, шинжээчдийнхээ анхдагч үнэлгээ, ур чадвар, гүйцэтгэл, мониторингийн талаар ISO/IEC 27006-1 стандартад тусгасан тусгай шаардлага болон ISO/IEC 17021, ISO 19011 стандартуудад үндэслэсэн баримтжуулсан журамтай байна. Баталгаажуулалтын байгууллага нь техникийн тодорхой хүрээнд аудитор / шинжээч бэлтгэх журамтай байна.

6 Баталгаажуулалтын байгууллагын Аудит хийх хугацаа

Баталгаажуулалтын байгууллага нь анхдагч баталгаажуулалт, магадлах хяналт, давтан баталгаажуулалт хийхэд шаардлагатай аудитын хүн өдрийг тодорхойлох журамтай байна. Уг журамд олон салбартай байгууллагад (multisite organisations) аудит хийх хугацааг тооцоолох, баталгаажуулалтыг шилжүүлэх тухай заалтуудыг оруулна.

Баталгаажуулалтын байгууллага нь дээрх журмыг ISO/IEC 27001 баталгаажуулалтын хүрээнд бий болгохдоо ISO/IEC 27006-1 стандартын С хавсралтад заасан зааврыг ашигласан байна.

---XXX---

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AC06	Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн шалгуур	
Хэвлэсэн огноо: 05.01.2023	Өөрчлөлт No:01	Хуудас: 2/3
	Өөрчлөлтийн огноо: 02.12.2024	

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ

Өөрчлөлтийн бүртгэл

<u>Өөрчлөлт No.</u>	<u>Огноо</u>	<u>Баталсан</u>	<u>Гарсан өөрчлөлт</u>
01	02.12.2024	MNAS дарга	Шинэчилсэн ISO/IEC 27006-1:2024 стандартын шаардлагад нийцүүлэв.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AC06	Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн шалгуур	
Хэвлэсэн огноо: 05.01.2023	Өөрчлөлт No:01 Өөрчлөлтийн огноо: 02.12.2024	Хуудас: 3/3

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ